

**Монгол улсын Их Хурлын тамга,  
тэмдгийн түүхээс**

*Доктор /Sc/, профессор Д.Өлзийдолгор*

1921-1924 онд Ардын Засгийн Газар, МАН-ын Төв Хорооноос авч явуулсан арга хэмжээнүүдийн үр дүнд Улсын их хурлыг хуралдуулах бэлтгэл ажил бүрэн хийгджээ. Иймд 1924 оны эхэн үеэс тулд Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох сонгуулийн ажлыг зохион байгуулсан байна. Тухайн үед мөрдөж байсан дүрэм, зааврын дагуу Их хурлын төлөөлөгчдийг нууц санал хураалтаар сонгожээ. Ардын Засгийн Газраас орон нутгуудад өгч байсан зааврыг үзэхэд "жинхэнэ ард" ангийн эрх ашгийг бодох туйлбартай хүмүүсийг сонгоход онцгой анхаарал тавьж байсан байдаг. Халх дөрвөн аймаг, дөрвөд хоёр аймаг, их шавь, Алтай ба Хөвсгөлийн урианхай хошууд, буриад хошууд, дарьганга, Ховдын тариачин хошууд болон ардын цэргээс бүгд 90 төлөөлөгч сонгосон байна. Жишээлбэл: Дөрвөдийн төлөөлөгч Бадрах гурван хуруу хэр хар хилэн эмжээртэй цагаан нэхий дээл, дөрвөд малгайтай байсан. Мөн малгайныхаа оройд улаан залаа хадсан буриад, шувууны өд хатгасан казак зэрэг олон үндэстэн ястны төлөөлөгчид анхдугаар их хуралд оролцсон гэж зарим хүмүүсийн дурьдатгалд тэмдэглэгдсэн байдаг. Дээр дурьдснаас үзэхэд, Улсын их хурал нь Монгол нутаг дахь олон үндэстэн ястныг оролцуулсан үндэсний хэмжээний хурал болсон нь тодорхой.

Монгол улсын Анхдугаар их хурал 1924 оны арван нэгдүгээр сарын 8-нд улсынхаа нийслэл Улаанбаатар хотноо нээгджээ. Одоогийн Улаанбаатар зочид буудлын буурин дээр байсан хоёр давхар туйпуун байшинд Анхдугаар Их хурал хуралдсан аж. Хурлын байрыг улаан өнгийн панс, элдэв зургаар чимэглэсэн байжээ. Гол хананд Лениний зураг, индрийн өмнө Сүхбаатарын хөргийг өлгөжээ. Мөн индрийн ар талд эвтэй дөрвөн амьтны зургийг өлгөсөн байсан [2.1] гэдэг. Хурлын төлөөлөгчдийн зүүн энгэрт улаан пансаар зангидсан цэцэг хадаж өгч байсан ажээ. [2.2] Энэ хуралд оролцохоор сонгогдсон төлөөлөгчдөөс 77 хүн хүрэлцэн иржээ. Төлөөлөгчдийн нийгмийн байдлыг үзвэл, тайж язгууртан 6, бусад нь ард гаралтай хүмүүс [2.3] байжээ. Тэдний 66 нь нам, эвлэлийн гишүүн, 70 нь бичиг үсэг мэддэг хүмүүс байсан гэж тэмдэглэгдсэн байна. Үүнээс үзвэл, манай улсын анхдугаар Их хурал тухайн үедээ нэлээд чадварлаг бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан учир төр засгийн бодлого чиглэл, үйл ажиллагааг нухацтай хэлэлцэн тодорхой шийдвэр гаргасан байна.

Улсын анхдугаар их хурлаас гаргах шийдвэрүүдийн итгэмжлэл баталгаажилт нь улсын дээд эрхийг барих их хурлын тамга байв. Иймээс Улсын Их хурал хуралдуулах бэлтгэл ажлын дотор Улсын Их хурлын тамга тэмдэг хийх асуудал нэн чухал байсан. Улсын Их хурлын тамга хийсэн түүхээс үзвэл, 1924 оны эхээр МАН-ын Төв Хорооны шийдвэрийн үндсэн дээр Ардын засгийн газраас Улсын Их хурлын "Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга" гэсэн үсэгтэй болд тамга, "Монгол улсын хурлын тэмдэг" гэсэн модон тэмдгийг тус тус үйлдүүлж хэрэглэх шийдвэр гаргажээ. [2.4] Энэ тухай Ардын Засгийн Газрын 32-р хурлаас, Улсын хурлын элдэв зүйлд дарах тамга тэмдэг хийлгэн үйлдүүлэх тухай бичигт: ...мөнөөхөн ардын засгийн Дотоод явдлын яамнаас Улсын хурлын элдэв хэрэг хэлэлцсэн хурлын тогтоол зэрэг бичиг хуудсанд дарах тамга буюу тэмдэг байваас зохих болов уу хэмээх тул хэрвээ үйлдүүлэх аваас алин нь юугаар үйлдэх ба үсгийг Монгол улсын хурлын тамга, Улсын хурлын газрын тэмдэг хэмээвээс болох эсэхийг тогтоомуй хэмээн хүргэж ирсэн тухайд манай засгийн газраас эл хэргийг хянан хэлэлцэж санал гаргаж ирүүлэхээр явуулжээ. Эдүгээ Монгол Ардын Намын Төв Хорооноос уг хэргийг тус хорооны тэргүүлэгчид хуралдсан дөчин долдугаар хурлын нэгдүгээр зүйлд хэлэлцээд, Улсын хуралд тамга, тэмдэг хоёуланг хэрэглэвээс зүйтэй тул уг тамганы үсгийг "Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга" хэмээн бичиж болдоор үйлдүүлэх ба тэмдгийн үсгийг "Монгол улсын хурлын тэмдэг" хэмээн модоор үйлдүүлж хэрэглүүлэх учрыг гаргаж тогтоон шийтгэмой хэмээн ирсэн тул хэлэлцээд ёсоор болгон баталж Дотоод яамнаас эрхлэн гүйцэтгэхээр тогтоов [1.1] гэжээ. Бас Монгол улсын

засгийн газраас МАН-ын Төв хороонд ирүүлсэн бичигт уг хурлын тамга, тэмдгийн үсэг нь юу болох, мөн юугаар үйлдэх зэргийг лавшруулах зорилгоор дахин хариу бичиг ирүүлжээ. Энэхүү бичигт: Монгол Ардын Намын Төв Хорооноо хуудсаар илгээх учир, мөнөөхөн ардын засгийн Дотоод явдлын яамнаас Улсын хурлын элдэв хэргийг хэлэлцсэн хурлын тогтоол зэрэг бичиг хуудсанд дарах тамга буюу тэмдэг байваас зохих болов уу хэмээх тул хэрвээ үйлдүүлэх аваас алин нь юугаар үйлдэх ба үсгийг "Монгол улсын хурлын газрын тамга", "Улсын хурлын газрын тэмдэг" хэмээвээс болох эсэхийг тогтоомуй хэмээн 514 тоот хуудсаар лавласан байна. Өмнө тогтсон тамга тэмдгийн нэрэн доор газрын гэдэг үгийг нэмж оруулсан. Үүнд зүй нь харъяат хуралд аливаа хэрэгт дарах тамга буюу тэмдэг олговоос зохих боловч тамга тэмдэгийг алины нь олгох, юугаар үйлдүүлэх үсгийг хэрхэн бичих зэргийг урьдаар зөвлөлдөн тогтоовоос зохихийн тул уг хуудас бичигт хуудас дагуулсан байна. Үүнийг Монгол Ардын Намын Төв Хорооноо явуулаад хүрмэгц байцаан үзэж дээр дурдсан хэргийг хянан хэлэлцэж саналыг илтгэн гаргаж ирүүлээд тогтоол шийтгэхэд бэлтгүүлсүгэй[1.2] хэмээн илтгэжээ.

Тус бичгийн хариуд: "мөнөөхөн ардын засгийн Дотоод явдлын яамнаас Улсын хурлын элдэв хэргийг хэлэлцсэн хурлын тогтоол зэрэг хуудсанд дарах тамга буюу тэмдэг байваас зохих болов уу хэмээх тул хэрвээ үйлдүүлэх аваас алин нь юугаар үйлдэх ба үсгийг "Монгол улсын хурлын тамга", "Улсын хурлын газрын тэмдэг" хэмээвээс болох эсэхийг тогтоомуй хэмээн хүргэж ирсэн тухайд манай засгийн газраас эл хэргийг хянан хэлэлцэж саналыг гаргаж ирүүлэхээр зохих газар явуулсан болой. Монгол Ардын Намын Төв Хорооноос эл хэргийг авч үзээд уг тамганы үсгийг "Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга" хэмээн бичиж болдоор үйлдүүлэх ба тэмдгийн үсгийг "Монгол улсын хурлын тэмдэг" хэмээн болдоор үйлдүүлэн хэрэглүүлэхээр хэлэлцсэн учрыг гаргаж тогтоон шийтгэмой хэмээсэн тул хэлэлцээд ёсоор болгон баталж Ардын Засгийн Дотоод яамнаас эрхлэн гүйцэтгэхээр тогтоожээ"[1.3]. Энд Улсын Их хурлын тамга, тэмдгэнд бичигдэх үгийн талаар өмнөх хоёр хувилбараас арай өөр болгожээ. Тухайлбал, "Ардын эрхт" гэдэг үгийг нэмж оруулан, "Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга" гэж тогтсон нь тухайн цагт ардын эрхийг тодруулах гэсэн байр суурийг баримтлахаар зорьж байсны илрэл юм.

МАН-ын Төв Хороо, Засгийн Газраас Улсын хурлын тамга тэмдэгийг хэв загвар ямар байх, юугаар үйлдэх талаар олон удаа хэлэлцэн тохиролцож байсан нь улсынхаа эрх барих дээд байгууллагын бүрэн эрх итгэмжлэл-хүндэтгэлийн илрэл юм. Ийнхүү "Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга", тэмдэгийг хэв загвар, юугаар хийхийг тогтсоны дагуу Монгол улсын анхдугаар их хурлын тамга тэмдэгийг үйлдүүлжээ. Улсын Анхдугаар Их хурлыг хуралдуулах, анхдугаар үндсэн хуулийг батлан гаргах бэлтгэл ажлын нэгэн чухал асуудал нь Улсын хурлын тамга, тэмдэгийг хийх ажил байсан нь дээрх баримтуудаас тодорхой харагдаж байна.

Чингис хааны алтан ургийн Цэрэндондовын Навааннэрэн 1922-1925 онуудад ардын Засгийн Дотоод яамны тэргүүн сайдаар ажиллаж байсан тул улсын хурлын тамга тэмдэг хийх ажилд биечлэн оролцсон байдаг. Баримтаас үзэхэд, Ц.Наваанэрэн нь 1924 оны XI сарын 8-наас 26-нд хуралдсан Улсын Анхдугаар Их хурлын 77 төлөөлөгчийн нэг нь байв. Махасамади далай сэцэн хан Цэрэндондовын Навааннэрэн Улсын Анхдугаар Их хурал нээгдсэн өдрийн 14 цагт төрийн дээд эрхийн билэг тэмдэг, баталгаа болсон "Ардын эрхтэй монгол улсын хурлын тамга" гэсэн үсэгтэй, дундаа соёмботой дөрвөлжин тамгыг Их хурлын дарга Жадамбаад ёслолын байдалтайгаар гардуулсан[1.4] нь төрийн дээд эрх тус хурлын мэдэлд шилжсэний гүн илэрхийлэл болжээ.[3.1] Дотоод явдлын яамны сайд Навааннэрэн: улс төрийн хэргийг улам улам бат сайнаар хөгжүүлтүгэй хэмээн ерөөл өргөж хурлын дарга Жадамбаад улсын их хурлын тамгыг гардуулжээ. Энэ ёслолыг Их хурлын төлөөлөгчид талархан хүлээн авсан бөгөөд хурлын дарга Жадамбаа тамганы хайрцагийг нээж "Ардын эрхтэй Монгол Улсын хурлын тамга" хэмээсэн үсэгтэй болохыг уншин сонсгож улсын дээд эрхийг тус хуралд хадгалж энэхүү тамгаар баталгаажуулах тухай илтгэсэн байна. Тамганы хэлбэр нь монгол улмжлалаар дөрвөлжин хэлбэртэй, дундаа соёмбо үсэг бүхий хоёр талаараа бичээс сийлж болдоор

хийсэн байжээ. Тамганы бичээсийг ухаж цэвэрхэн сийлж хийсэн ба үгийн багтах зайг нь харгалзан тэгш хуваарилан хоёр талд нь байрлуулсан байна.

### Улсын Анхдугаар их хурлын тамга.



Энэ тамга нь “**Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга**” гэсэн бичээстэй байна.


/Дээр тогтсон ёсоор хийсэн тамга болно/

Энэ тамгыг анх барьж хурлаас гарсан шийдвэрүүдийг баталгаажуулсан хүн бол Улсын Анхдугаар Их хурлын дарга Жадамбаа болно. Монгол улсын үндэсний түүхийн төв архивт хадгалагдаж байгаа анх дугаар үндсэн хуулийн хуудас бүрт “Ардын эрхтэй Монгол улсын хурлын тамга ” гэсэн үсэгтэй тамгыг дарсан эх бий.[1.5] Энэ эх дээр Улсын их хурлын дарга, тэргүүлэгчид бүгд гарын үсгээ зуржээ.

Анхдугаар үндсэн хуулиар “ Монгол улсыг Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ардын Эрхтэй Улс” хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн төрийн дээд эрхийг Улсын их хуралд хадгалуулахаар заасан. Үндсэн хуулиараа улсынхаа нэрийг тогтсон тул төрийн бүх тамга тэмдэгийн үгийг /бичээсийг/ өөрчлөх шаардлагатай болсон. Монгол улсын төрийн бүх байгууллагын тамга, тэмдэгт Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ) гэсэн нэрийг оруулах болсон тул 1921 оноос хийгдсэн бүх тамганд өөрчлөлт орж, шинээр үйлджээ. Монгол улсын Их хурлын тамга ч мөн адил “Ардын эрхтэй Монгол улсын тамга” хэмээхийг “БНМАУ-ын их хурлын тамга ” гэж өөрчлөх шийдвэр гаргажээ. Ардын засгийн газраас Улсын их хурлын тамганы үсгийг залруулан үйлдэж хүргүүлэн ирсэн хэрэг гэсэн нэгэн бичигт: Монгол Ард улсын Засгийн газраас Монгол Ард Улсын Бага Хурлын тэргүүлэгчдэд хуудсаар илгээв. Хүргүүлсэний учир, Эдүгээ дотоод явдлын яамнаас хүрч ирсэн хуудсанд Ерөнхий хэлтсийн өргөсөн нь, мөнөөхөн засгийн газрын хуралд олон яам зэрэг газруудаас тамганы үсгийг БНМАУ-ын хэмээн үйлдүүлэхээр тогтсон учир манай яамнаас Улсын их хурлын тамганы үгийг (бичээсийг) залруулан үйлдүүлж түшмэл Бадрахад тушаан өгч хүргүүлсэн. Үүнийг БНМАУ-ын засгийн газар хуудсаар өргөн явуулаад хүлээн авч уламжлан олгуулах ажаамуй хэмээн өргөжээ. Үүний тул өргөн илгээв” хэмээн таван тоот хуудсаар хүргүүлсэн гэсэн байдаг.

Анхдугаар Үндсэн хуулийн зургадугаар бүлэгт: БНМАУ-ын сүлд тэмдэг нь соёмбо үсэг, түүний доод этгээдэд бадамлянхуа цэцгийн зураг бүхий байна гэж заасан. Улсын Их хурал болон Засгийн газар, олон явдлын яам, албаны газруудын тамгыг цөм дөрвөлжин бөгөөд нүүрийн дунд хэсэгт Соёмбо гэдэг эрхэм үсэг, түүний хоёр этгээдэд уул газрын нэр сэлтийг үйлдүүлэн гүйцэтгүүлвэл зохино гэж төр, албаны тамганы загварыг тогтоожээ. Энэ заалтын дагуу үүнийг Улсын Бага хурлын тэргүүлэгчдэд явуулаад хүрмэгц хүлээн авч гүйцэтгэн шийтгэх ажаамуй. Нарийн бичгийн дарга Ламжав”[1.6] гэж заасан байна.

**Монгол Улсын анхдугаар үндсэн хуулиар батласан БНМАУ-ын сүлд тэмдэгний дардас**



**Сүлдний хоёр талд Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн бичээс байна.**

Улмаар улсын Их хурлын тамганы хайрцагийг цоож түлхүүрийн хамт шинэчлэн үйлдвээс зохих ба бас Улсын бага хурал ба эдийн засгийн зөвлөлийн тамганы хайрцаг мөн цоож түлхүүр, мөн тамганы тосны савыг үйлдүүлсүгэй. Тус бүр нэжгээдийг тус тус үйлдүүлэн эрхэлбээс зохихын тулд Монгол Ард Улсын аж ахуйн яамнаа явуулан хянан үзэж эл тамганы хайрцаг зэргийг тооны ёсоор үзэмжтэй сайнаар нэн даруйхан үйлдүүлж ирүүлээд, улмаар хүргүүлэн хэрэглүүлэхэд бэлтгүүлсүгэй[1.7] гэсний дагуу БНМАУ-ын Улсын их хурлын тамгыг үйлдүүлэн хэрэглэжээ.



Тамганы бичээс нь: **Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын Тамга** гэж монгол бичгээр бичжээ. 1924 оноос 1940 он хүртэл энэ тамга эрхэмлэгдэж байсан. [2.5]

Улсын Их хурал нь жил тутам хуралдаж хууль тогтоох, гадаад орнуудтай харилцах асуудлууд болон засгийн газар, яам, тусгай газрууд, аймгуудын илтгэлийг нэг бүрчлэн хэлэлцэж тогтоол шийдвэр гаргадаг байв. Зарим үед сар гаруй хугацаагаар ч үргэлжилсэн хуралдаан болж байжээ. Цаашдаа төр засгийн байгуулагуудын ажил үүргийн хуваарь нарийсч ирсэн тул Улсын Их ба Бага хурлуудаар улс орны хөгжлийн чиг удирдамжийн чухал асуудлуудыг хэлэлцэх болсон. Улсын Их Хурал нь Улсын Бага хурал, Засгийн Газраас боловсруулсан асуудлуудыг голлон хэлэлцдэг болсон байна.

1940 онд хуралдсан Улсын наймдугаар их хурлаас "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрхийг барих дээд газар нь Улсын их хурал мөн. Улсын их хурал бол хот ба аймгийн түр хурлуудаас 1500 хүн тутмаас нэг төлөөлөгч сонгогдон хот аймгийн хөдөлмөрчдөөс байгуулагдана" гэж заасан. 1940 онд Улсын наймдугаар Их хурлаас батлагдсан шинэ үндсэн хуулиар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн /Сайд нарын Зөвлөлийг 1938 онд байгуулсан байна/ эрх үүргийн дотор: засаг төрийн албан газруудад хэрэглэх улсын сүлд тэмдэг бүхий тамга тэмдэг хийлгэх зөвшөөрөл олгох ба түүний маягийг батлана[1.8] гэж заажээ. Мөн хуулийн арван нэгдүгээр бүлгийн зуун тавдугаар зүйлд : БНМАУ-ын сүлд тэмдэг бол дугуй хэлбэртэй, дунд нь монгол улсын хангай, тал, говь нутаг дээр нарны зүг уурга барин давхиж яваа морьтой ард байх ба дугуйн хөвөөгөөр өвс ногоон дээр хонь, үхэр, тэмээ, ямааны толгойг хоёр талд нь зурж, дугуйн дээд талыг дан алхан хээгээр хүрээлж, дунд нь таван хошуу тэмдэг байна. Өвс ногооны

доод уулзварт улаан лент дээр /Бүгд Найрамдах Монгол Ард Улс/ гэж бичсэн байна гэжээ.

**1940 онд Улсын наймдугаар их хурлын баталсан  
БНМАУ-ын сүлд тэмдэг.**



**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын энэ сүлд 1940-1960 он  
хүртэл эрхэмлэгдэж байсан.**

1941 оны XI сарын 16-ны өдөр БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 73-р хурлаас гаргасан тогтоолын нэгдүгээр зүйлд: улсын их хурлын тамга нь дугуй хэлбэртэй бөгөөд хайш хайшаа 9 см, 2мм-ийн хэмжээтэй байх ба төвдөө 8 см-ийн хэмжээний сүлд /шинэ сүлд/ баймой. Сүлдний гадна талын дүгрэг хүрээнд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их хурал хэмээсэн Монгол үсэгтэй баймой”[1.9] гэж заажээ.

Улсын Их хурлыг байгуулах тухай өмнөх шийдвэрийн заалтыг 1957 онд Их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар өөрчилж, “Улсын Их хурлыг 3500 хүн тутмаас нэг депутатаар бодож сонгуулийн тойргуудаар БНМАУ-ын ард иргэд сонгоно” гэсэн шинэ заалт гаргажээ[2.6].

Монголчууд 1930-аад оноос латин үсгийг өөрийн хэлэндээ зохицуулан хэрэглэх оролдлоо хийж байв. Латин бичиг зааж сургах, сонин сэтгүүлд булан нээх зэргээр арваад жилийн нүүр үзжээ. 1941 онд МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн хавсарсан хурлаар авч хэлэлцээд гуравдугаар сарын 25-ны өдөр 22/18 тогтоол гарган латин үсгийг хэрэглэхгүй болсон. Уг тогтоолд “...монгол үсгийг латинчлахад монгол үгэнд хэрэглэгдэх тэмдэг дутагдалтай ба мөн хэвлэлийн талаар дутагдах зэрэг техникийн бэрхшээл тохиолдож байна. Басхүү тус орны соёл боловсролын цаашдын хөгжилт нь гагцхүү ЗХУ-ын ард түмэнтэй ах дүүгийн холбоог бэхжүүлэн түүний баялаг соёлыг эзэмшүүлэх замаар явах болно. Монгол бичгийг шинэ орос үсэг дээр шилжүүлэн авах явдал чухал хэмээн үзмой ” гэж тэмдэглээд[3.2] орос шинэ үсэг-кирилл үсэг хэрэглэх болжээ. Шинэ үсэг хэрэглэх дүрэм зохиох комиссыг Ю.Цэдэнбалаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Энэ дүрмийг Ц.Дамдинсүрэн гуай голлон зохиосон гэдэг. 1942 онд уг дүрэм бэлэн болсон боловч дэлхийн II дайны дараа 1946 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүх хэвлэл улсын албан хэргийг шинэ үсгээр явуулах болжээ. Энэ үеэс эхлэн БНМАУ-ын төр, захиргааны тамга, тэмдэг бүгд кирилл үсгээр бичигдэх болсноос өмнө үеийн тамга, тэмдэгүүдийг өөрчилсөн байна. 1946 оноос Улсын Их, Бага хурлын тамга тэмдгийг мөн өөрчилсөн. Энэ үеэс кирилл үсгээр бичигдсэн тамга эрхэмжлэгдэх болжээ.



## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС

**Улсын их хурлын тэргүүлэгчдийн газар** гэсэн бичээстэй энэ дугуй тамгыг 1946-1960 оны хооронд хэрэглэжээ.

БНМАУ-ын Улсын Их хурлын үйл ажиллагаанд 1949 онд хуралдсан Улсын IX их хурал чухал үүрэг гүйцэтгэв. Дайны үе болон нэг хүнийг тахин шүтэх ёс ноёрхсоны улмаас төрийн ардчилал ихээхэн алдагдаж, урьдах их хурлаас хойш өсөн жил гаруйн дараа хуралдсан тус их хурал нь Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын Бага Хурлыг татан буулган Улсын их хурлыг төрийн дээд эрх барих, хууль тогтоох байгууллага болгожээ. Мөн энэ их хурлаас БНМАУ-ын сонгуулийн системийг өөрчлөх шийдвэр гаргав. Энэ үеэс улсын их хурлын чуулган, байнгын комисс, сонгуулийн тойрог гэдэг зохион байгуулалтын шинэ хэлбэр, ардчилалын шинэ механизм бий болжээ.

1951 онд Улсын Их хурлыг анх удаа сонгуулийн шинэ системээр сонгогдсон 295 төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Мөн оны долдугаар сарын 6-7-нд хуралдсан түүний анхдугаар чуулганаар БНМАУ-ын Их хурлаас гаргасан шийдвэрийг хууль гэх ба тэргүүлэгчдийн тогтоолыг зарлиг гэж нэрлэн тэдгээр байгууллагын эрх зүйн зарчмыг тодорхойлов.[3.3]

Монгол улсын хууль тогтоох дээд байгууллага нь Улсын Их хурал нэрээр 1949 оноос 1960 оны долдугаар сар хүртэл ажилласан байна.

1960 оны Үндсэн хуулийн 9-р бүлэг 90 дүгээр зүйлд. "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн сүлд бол төрийн мөн чанар, улс түмний найрамдлын үзлийг илэрхийлэн тус орны үндэсний болон эдийн засгийн онцлогийг үзүүлсэн гэж тэмдэглээд БНМАУ-ын сүлд бол тариан түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байна. Тарианы ишийг хүрд араагаар холбож, эдгээрийг "БНМАУ" гэсэн үсэг бүхий улаан, цэнхэр өнгийн туузаар ороож зангидсан байна. Сүлдний төвд БНМАУ-ын хангай, говь, тал хосолсон нутгаар мандах коммунизмын наран өөд хурдалж яваа морь унасан хөдөлмөрчин хүн зурсан байна. Сүлдний магнайд тариан түрүүний хоёр үзүүрийн хооронд дундаа алтан соёмбо үсэг бүхий таван хошуу байна гэж тогтсон. Үүгээр БНМАУ-д үйлдвэржилт, газар тариалан хөгжиж байгааг илүүтэй харуулжээ.

**1960 оны гурав дахь үндсэн хуулиар баталсан сүлд тэмдэг**



Ардын төрийн эрх барих дээд байгууллага БНМАУ-ын Их Хурлыг 1960 оны Үндсэн хуулиар Ардын Их хурал гэж нэрлэснээс тамгыг өөрчлөх шаардлагатай болжээ. БНМАУ-ын төрийн шинэчилсэн сүлдийг тамганд оруулах ба БНМАУ. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн Газар гэсэн бичээс оруулж тамгыг шинээр хийж төрийн үйл хэргийг эрхэмжлэх болсон байна.

БНМАУ-ын Ардын Их хурлын тэргүүлэгчдийн газар гэсэн бичээстэй энэ тамга нь 1990-ээд оны эхэн хүртэл төрийн дээд эрхийг баталгаажуулж байжээ. Уг тамгыг доорхи дардсанаас үзнэ үү.[1.10]



БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар БНМАУ-ын төрийн билэг тэмдэгийн тухай дүрмийг батлажээ. Энэ дүрмэнд: БНМАУ-ын АИХ түүний тэргүүлэгчид, БНМАУ-ын СнЗ, Яам, Улсын Хороо, Тусгай газар, орон нутгийн ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргаа, БНМАУ-ын дипломат худалдааны төлөөлөгчдийн болон консулын газар, түүнчлэн БНМАУ-ын хууль тогтоомжоор эрх олгогдсон албан газар байгууллагын тамга тэмдгэнд төрийн сүлдийг оруулсан тамга хэрэглэнэ гэж заасан. Энэ дүрэм Монгол Улсын Засгийн Газрын 1992 оны хоёрдугаар сарын 14-ний өдрийн 26-р тогтоолоор батлагдсан "Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх хэрэглэх заавар"-ыг батласнаар хүчингүй болсон юм. Мөн 1960 оны үндсэн хуулиар батлагдсан төрийн сүлдийг өөрчлөх тухай Улсын Их Хурлын 1994 оны 39-р тогтоол гарчээ. БНМАУ-ын Ардын Их хурал нь 1990-ээд оныг хүртэл монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага байсаар ирсэн түүхтэй билээ.

## Сэдвийн эшлэл зүүлт

### 1. Архивийн баримтууд

- 1.1. Монгол Улсын Түүхийн Төв Архив. /МУУТТА/ Ф-1, Д-2, Хн-126, 42 дэх тал.
- 1.2. МУУТТА. Ф-1, Т-1, Хн-176. 1923 он. 229-230 дэх тал.
- 1.3. МУУТТА. Ф-1, Т-1 Хн-280. 20-р тал.
- 1.4. МУУТТА. Ф-1, Т-1, ХН-313.
- 1.5. МУУТТА. Ф-11, Т-5, Хн-10
- 1.6. МУУТТА. Ф-1, Т-1. Хн-49. 76-р тал
- 1.7. МУУТТА. Ф-1. Т-2. Хн-16. 16-17-р тал
- 1.8. МУУТТА. Ф-11, Т-1, Хн-999. 6-р тал
- 1.9. МУУТТА. Ф-11, Т-1, Хн-187. 339-440
- 1.10. МУУТТА. Ф-11, Т-1, Хн-1767. 76-р тал

### 2. Эх сурвалж

- 2.1. Ардын эрх сонин. 1924-ХI-18. №368
- 2.2. МАХН-ын ахмад ажилтан, гишүүдийн дурьдатгал. I боть. УБ., 1978 он 28 дахь тал
- 2.3. Бүгд Найрамдах Монгол Ард улсын анхдугаар Их хурал. УБ., 1984 он., 7 тал
- 2.4. Монголд Бүгд Найрамдах засгийг тогтоон явуулсан нь. УБ., 1970 он
- 2.5. Үндэсний Түүхийн Музейн сан хөмрөгөөс олсон болно.
- 2.6. Монгол улсын үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. /1921-1992 он/ УБ., 1998 он. 18-р талд

### 3. Судалгааны бүтээлүүд

- 3.1. Д.Өлзийдолгор Х.Ариун-Эрдэнэ. Махасамади далай сэцэн хан Цэрэндондовын Наваан нэрэн. УБ., 2000 он. 42-р тал.
- 3.2. Монголын соёлын түүх. дэд боть. 1999 он. 30-31-р тал.  
XX зууны Монгол. Ред. М.Санждорж. УБ., 1995 он. 81-р тал.

## “History of the seals of the State great Khural”

### Summary

*D. Uziidolgor*

The article about the seals of the State Great Khural and state symbols in the last century. It illustrates the major changes of the state symbols and seals since the declaration of the Mongolian republic and new Constitution of Mongolia in 1924.